



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/783

Арвайхээр


**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай**

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дууссан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг харгалзан 5 дугаар багийн Гэндэнгийн гудамж 201 тоотод байрлах Даваадорж овогтой Жаргалын (ЙЮ58022600) эзэмшлийн амины орон сууцны зориулалттай 1118м² газрын, 5 дугаар багийн Гэндэнгийн гудамж 200 тоотод байрлах “Дэлгэрэх хүнс” ХХКомпаний (2015595) эзэмшлийн 1231м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь сунгагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101708